

Сургууль хаагдсан тохиолдолд гэрээсээ зайнаас хичээллэх нь

Эцэг эх асран хамгаалагчдад зориулсан мэдээлэл

Хэрэв таны хүүхдийн сурдаг сургууль хаагдах шаардлагатай болсон бол сургууль эцэг эх асран хамгаалагчидтай өөрийн мэдээллийн сувгаараа харьцах болно. (энэ нь e-мэйл, SMS болон веб хуудас гэх мэт байж болно.)

Хэрэв сургууль удаан хугацаагаар хаагдах болсон бол таны хүүхдийг гэртээ сурах боломжоор хангасаар байх бөгөөд энэ талаар тантай холбогдох болно.

Тус муж улсын олон сургуульд багш нар хичээлийг сурагчдад зайнаас сургах явцыг амжилттай хэрэгжүүлж эхэлсэн. Зарим сургуулиуд таны хүүхдийн суралцах ёстой хичээлүүдийн бүгдийг эсвэл олонхийг зайн сургалтаар хэрэгжүүлж байгаа. Зайн сургалтын хүрээнд зарим хичээлийг онлайнаар лайв хүргэж байгаа. Хэрэв сургууль онлайнаар сургалтаа явуулах боломжгүй, эсвэл танд онлайн хичээл хийлгэх боломж байхгүй бол сургууль сурагчдад хичээлийг даалгаврыг хийх хуудсууд, ном, товхимол, эсвэл хичээл даалгаврыг багтаасан USB-д суулган өгөх юм уу e-мэйлээр илгээх болно.

Багш нар сурагчидтай хэсэгчилсэн байдлаар буюу ганцаарчлан утсаар холбогдох боломжтой.

Мэдээллийн хуудас нь танд хүүхдээ гэрийн нөхцөлд зайн сургалтанд хэрхэн хамрагдуулах талаар ойлголт өгөх зорилготой болно.

- Таны үүрэг – та хүүхдээ хичээл хийх цаг гаргаж өгөх, хүүхдээ хичээллэх чимээгүй орчинг бүрдүүлж өгөх, хичээлээ хэр сайн хийж байгааг байнга асууж магадлаж байх зэргээр хүүхэдтэйгээ ажиллах үүрэг хүлээнэ.
- Сурагчийн үүрэг – багшаас даалгаж өгсөн хичээлийг зааврын дагуу цагт нь хийж дуусгасан байх үүрэгтэй.
- Сурагчийн хичээлийн өдрийг хэрхэн төлөвлөх вэ – сургуулийн зүгээс таны хүүхэд өдрийн турш юу хийвэл зохих талаар танд зөвлөх болно.
- Сурагчийн эрүүл мэндэд анхаарал тавих – Хүүхэд хичээлээ хийх явцдаа завсарлага авч байгаа, хангалттай ус ууж багаа эсэх, мөн сэтгэл санаа нь хямрахгүй гутралд ороогүй зэргийг магадлаж байгаарай.
- Харилцаа холбоо – Хүүхэдтэйгээ хичээл сурлагынх нь талаар байнга ярилцах нь маш чухал юм. Таны хүүхдийн багш эсвэл сургууль тантай холбогдох бөгөөд тэдэнтэй та хэрхэн холбогдож болох талаар танд зөвлөх болно.
- Технологи болон дэлгэцэн дээр өнгөрөөх хугацаа – таны хүүхэд технологийг аюулгүйгээр ашиглаж буйг, мөн хүүхдийн онлайн өнгөрөөж буй цагийг хянаж байх нь маш чухал юм.

Утсан орчуулгын үйлчилгээ

Хэрэв танд нэмэлт мэдээлэл хэрэгтэй бол сургуулийн захиралтай холбогдоорой. Хэрэв танд орчуулагч хэрэгтэй бол Утсан Орчуулгын Үйлчилгээний төвтэй 131 450 дугаараар холбогдон өөрийн хэл дээр орчуулгын үйлчилгээ авч болно. Энэ үйлчилгээ нь үнэ төлбөргүй болно.